



МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2022 оны 12 сарын 01 өдөр

Дугаар A-336

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1,2 дахь заалт, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Банкны мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Банкны мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд зайнас хяналт тавих журам”-ыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны А-293 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Ц.Нарандалай)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

Б.ЛХАГВАСҮРЭН



1522012352

Монголбанкны Ерөнхийлогчийн 2022 оны
11 дугаар сарын 01-ний одрийн 00:00
дугаар тушаалын хавсралт-



БАНКНЫ МОНГО УГААХ, ТЕРРОРИЗМЫГ БОЛОН ҮЙ ОЛНООРХАНООХ ЗЭВСЭГ
ДЭЛГЭРҮҮЛЭХХИЙГ САНХҮҮЖУЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАЛД ГАЗАР
ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДСЛЭЛ

1.1. Монго угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмийт тэмцэх тухай хууль, бусад хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэх зорилгоор Монголбанкнаас гаргасан цүрэм, журам, заавар, удирдамж, зовломжийг банк оорийн бүтэц зохион байгуулалт, бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэр болон үйл ажиллагааны цар хүрээтгэй уялдуулан хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих, Монголбанкнаас үүрэг даалгавар огох, монго угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх (цаашид “МУТС/YOХЗДС” гэх)-тэй тэмцэх үйл ажиллагаанд эрсдэлд сууринсан газар дээрх хяналт шалгалт хийх, үнслэлт, дүгнэлт, дүгнэлт огоход энэ журмыг морилог болгоно.

1.2. Энэ журмаар зайны хяналтын дүгнэлтгэдүнд сэлжүүлж бий болсон банканд хийх газар дээрх хяналт шалгалтын чиглэлийг тодорхойлох богоод энэ нь нэмэлт үзүүлэлтээр хийх хяналт шалгалтын ажиллагааг хязгаарлахгүй.

1.3. МУТС/YOХЗДС-тэй тэмцэх чиглэлээр банканд хийгдэх газар дээрх хяналт шалгалтын удирдамжийг Монголбанкны Ерөнхийлогч батална. Шаардлагатай тохиолдолд удирдлагын баталсан томилолтын дагуу газар дээрх хяналт шалгалтыг гүйцэтгэж болно.

1.4. Газар дээрх хяналт шалгалтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- 1.4.1.Хяналт шалгалтын бэлтгэл ажлыг хангах;
- 1.4.2.Хяналт шалгалтыг хийж гүйцэтгэх;
- 1.4.3.Хяналт шалгалтын тайлан боловсруулах, удирдлагад танилцуулах;
- 1.4.4.Бусад шаардлагатай, нэмэлт үйл ажиллагаа.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ

2.1. Газар дээрх хяналт шалгалтыг хийхийн омно хялан шалгагч нь дараах баримт, мэдээллийн танилцсан байх шаардлагатай:

- 2.1.1.Банкны МУТС/YOХЗДС-тэй тэмцэх үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийн үнэлгээний тайлан;
- 2.1.2.Омнох хяналт шалгалтын тайлан, Монголбанкнаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт;
- 2.1.3.Банкны дотоод болон хондлонгийн аудитын тайлан;
- 2.1.4.Зайны хяналт шалгалтын тайлан;
- 2.1.5.Шаардлагатай бусад мэдээлэл.

2.2.Газар дээрх хяналт шалгалтын бэлтгэл ажлыг хангахдаа “МУТС/YОХЗДС-тэй тэмцэх үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх гарын авлага”-ыг баримтална.

2.3.Газар дээрх хяналт шалгалт хийхэд шаардлагатай урьдчилан бэлтгэх баримт, материалын жагсаалтыг энэ журмын нэгдүгээр хавсралтын дагуу тодорхойлно.

ГУРАВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТӨРӨЛ БА ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛ

3.1.Эрсдэлд суурилсан газар дээрх хяналт шалгалт нь дараах хэлбэртэй байна:

3.1.1.Иж бүрэн хяналт шалгалт: Энэ журмын 3.3-т заасан үндсэн чиглэлийн нийт үзүүлэлт, шаардлагатай нэмэлт үзүүлэлтээр хийх хяналт шалгалт;

3.1.2.Хэсэгчилсэн хяналт шалгалт: Энэ журмын 3.3-т заасан үндсэн чиглэлийн үзүүлэлтүүдээс тодорхой чиглэлээр хийх хяналт шалгалт;

3.1.3.Гүйцэтгэлийн хяналт шалгалт: Монголбанкнаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг шалгах хяналт шалгалт;

3.1.4.Сэдэвчилсэн хяналт шалгалт: Тухайлсан сэдвээр хийх хяналт шалгалт.

3.2.МУТС/YОХЗДС-тэй тэмцэх чиглэлээр банканд хийх хяналт шалгалтыг үндсэн чиглэлийн үзүүлэлт болон нэмэлт үзүүлэлтээр хийнэ.

3.3.Банкны МУТС/YОХЗДС-тэй тэмцэх үйл ажиллагаанд хийх газар дээрх хяналт шалгалтын үндсэн чиглэлд дараах үзүүлэлтүүд багтана:

3.3.1.Банкны бүтэц зохион байгуулалт, Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТҮЗ” гэх) болон түүний дэргэдэх хороод, дотоод бодлого, журам;

3.3.2.Хэрэгжилт хариуцсан нэгж, чиг үүрэг, ажилтан;

3.3.3.Харилцагч, бүтээгдэхүүн үйлчилгээ түүнийг харилцагчид хургэх арга хэлбэр, үйл ажиллагааны цар хүрээ, газарзүйн онцлогоос учирч болзошгүй МУТС/YОХЗДС эрсдэлийг үнэлэх аргачлал, үр дүнтэй байдал;

3.3.4.Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа;

3.3.5.Харилцагчийг таньж мэдэх хялбаршуулсан үйл ажиллагаа;

3.3.6.Харилцагчийг нарийвчлан таньж мэдэх үйл ажиллагаа;

3.3.7.Эцсийн омчлогчийг тогтоох, тодорхойлох үйл ажиллагаа;

3.3.8.Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаанд гуравдагч этгээдийг ашиглахтай холбоотой зохицуулажт;

3.3.9.Улс төрд нөлөө бүхий этгээдийг таньж мэдэх, хяналт тавих үйл ажиллагаа;

3.3.10.МУТС/YОХЗДС-тэй тэмцэх, ондор эрсдэлтэй орнуудад авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа;

3.3.11.Банкнаас “Монгол Угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлд заасан мэдээлэх үүрэгтэй этгээдэд хяналт тавих үйл ажиллагаа;

3.3.12.Данс, гүйлгээнд тусгайлан хяналт тавих үйл ажиллагаа;

3.3.13.Сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээлэх үйл ажиллагаа;

3.3.14.Бэлэн монгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээг мэдээлэх үйл ажиллагаа;

3.3.15.Хил дамнасан корреспондент банкны үйл ажиллагаа;

3.3.16.МУТС/YОХЗДС-тэй тэмцэхд чиглэсэн банкны дотоод хяналт шалгалтын

тогтолцоо, арга хэлбэр;

3.3.17.Цахим гүйлгээнд хяналт тавих үйл ажиллагаа;

3.3.18.Шинэ технологи, бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагаа;

3.3.19.Баримт, материалын хадгалаалтын байдал;

3.3.20.МУТС/YОХЗДС-тэй тэмцэхэд чиглэсэн сургалтын чанар, хөтөлбөр, хэрэгжилт.

3.4.Банкны МУТС/YОХЗДС-тэй холбоотой эрсдэлээс хамаарч нэмэлт үзүүлэлтээр хяналт шалгалт хийж болох бөгөөд тухайн үзүүлэлт бүрд үнэлэлт өгно.

3.5.Газар дээрх хяналт шалгалтын үр дүн болон Монголбанкнаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, банкнаас ирүүлсэн статистик мэдээлэл зэрэгт үндэслэн энэ журмын хоёрдугаар хавсралт буюу газар дээрх хяналт шалгалтын аргачлалыг шинэчилж болно.

3.6.Үндэсний эрсдэлийн үнэлгээ, Монголбанкнаас тодорхойлсон МУТС/YОХЗДС эрсдэлийг харгалзан энэ журмын 3.3-д заасан чиглэл, үзүүлэлтэд нэмэлт, оорчлолт оруулж болно.

3.7.Хянан шалгагч нь үндсэн чиглэл, нэмэлт үзүүлэлтээр хяналт шалгалт хийхдээ хоёрдугаар хавсралт буюу газар дээрх хяналт шалгалтын аргачлал, “МУТС/YОХЗДС-тэй тэмцэх үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх гарын авлагаг”-ыг ашиглана.

ДӨРӨВ. ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ

4.1.Хяналт шалгалтыг хийхдээ дараах дарааллыг баримтална:

4.1.1.Хяналт шалгалтыг эхлүүлэх уулзалтыг зохион байгуулж, хяналт шалгалтын удирдамж, зорилго, шалгалттай холбоотой гаргуулан авах мэдээллийн талаар банкны удирдлагад танилцуулах;

4.1.2.Хяналт шалгалт хийхэд шаардлагатай мэдээллийг нэгдүгээр хавсралтад заасны дагуу гаргуулж авах;

4.1.3.Газар дээрх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэх;

4.1.4.Хяналт шалгалтын тайланг боловсруулах, дүгнэх;

4.1.5.Хяналт шалгалтын үр дүнг банкны удирдлагад танилцуулж, тайлбар авах;

4.1.6.Иж бүрэн хяналт шалгалтын тайлан боловсруулах, хяналт шалгалтын үр дүнг тайлагнахдаа энэ журмын гуравдугаар хавсралтад заасан газар дээрх иж бүрэн хяналт шалгалтын тайлангийн загварыг ашиглана.

4.2.Хяналт шалгалтын чиглэл тус бүрд дараах хүснэгтийн дагуу үнэлгээ өгно.

Үнэлгээ	Үндэслэл
1 буюу “сайн”	Хянан шалгагчийн үнэлгээ, шинжилгээний асуулгын хариулгад алдаа дутагдал байхгүй, банк нь хуулийн шаардлагыг хангасан бодлого, дотоод журамтай, дотоод хяналтын тогтолцоо, үйл ажиллагаа нь (удирдлагын хяналт, хэрэгжилт гэх мэт) сайн.
2 буюу “хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд”	Банк нь хуулийн шаардлагад нийцсэн дотоод бодлого журамтай, үйл ажиллагаа, удирдлагын тогтолцоо, хяналт нь үр дүнтэй бөгөөд илэрсэн дутагдлыг газар дээрх хяналт шалгалтын явцад арилгуулах боломжтой.

3 буюу “дутагдалтай”	Бодлого, журам нь банкны үйл ажиллагааг бүрэн хамраагүй, хуулийн шаардлагад нийцэгүй, үйл ажиллагаа нь зарим талаараа дутагдалтай, удирдлагын хяналтын тогтолцоог зарим талаар сайжруулах шаардлагатай.
4 буюу “ихээхэн дутагдалтай”	Банкны бодлого, журам нь хуульд нийцэгүй бөгөөд МУТС/YОХЗДС-тэй тэмцэх үйл ажиллагаанд ТУЗ, гүйцэтгэх удирдлагын хяналт, оролцоо сул, үйл ажиллагаа нь ихээхэн дутагдалтай.
5 буюу “хангалтгүй”	Бодлого, журам нь хуульд нийцэгүй бөгөөд ТУЗ, гүйцэтгэх удирдлагаас МУТС/YОХЗДС-тэй тэмцэх үйл ажиллагаанд хяналт тавьдагтүй, дотоод хяналтын болон тайллагнах механизмыг байхгүй, бие даасан комплаенсийн бүтэцгүй, сургалт хийдэггүй зэрэг дутагдалтай.

4.3.Хяналт шалгалтын үнэлгээгээр З болон түүнээс муу үнэлгээ авсан, зөрчлийн шинжгүй гэж үзвэл дутагдлыг сайжруулах дараах арга хэмжээг авна. Үүнд:

- 4.3.1.Дутагдлыг засах, урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөмж, сануулга өгөх;
4.3.2.Дутагдлыг арилгуулахтай холбоотой хугацаатай үүрэг даалгавар өгөх;

4.4.Өмнө илэрсэн дутагдлыг засаж, сайжруулах талаар арга хэмжээ аваагүй, давтан гаргасан тохиолдолд дараах хүснэгтэд заасны дагуу арга хэмжээ авна:

Авах арга хэмжээ	1 удаа	2 удаа	3 удаа болон түүнээс дээш
	Зөвлөмж, сануулга өгөх	Хугацаатай үүрэг даалгавар өгөх	“Зөрчлийн хууль”-ийн дагуу арга хэмжээ ¹ авах.

ТАВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН МОРООР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

5.1.Ажлын хэсэг нь шалгалтын танилцуулга, тухайн банканд авсан арга хэмжээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналаа Банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт тавих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, танилцуулна.

5.2.Банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт тавих зөвлөлийн хурлаас гаргасан санал, дүгнэлтэд үндэслэн Монголбанкны Ерөнхийлогч шийдвэр гаргана.

5.3.Шалгалт хийгдсэн банканд Монголбанкны Ерөнхийлогчийн шийдвэрийг хүргүүлж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллана.

ЗУРГАА. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСГИЙН ҮҮРЭГ

6.1.Ажлын хэсгийн ахлагч, гишүүд нь Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, бусад хууль тогтоомжид заасан эрх, үүргийг хэрэгжүүлж, Монголбанкны Улсын байцаагчийн дүрмийг баримтлан ажиллана.

6.2.Шалгалтгтай холбоотой гомдол, санал, тайлбарыг хүлээн авах, шийдвэрлэхэд Монголбанкны Улсын байцаагчийн дүрмийг баримтална.

¹ Шаардлагатай гэж үзвэл дутагдлын шинж чанараас нь хамаараад “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-ийн 23.2-т заасан арга хэмжээг хавсрсан хэрэгжүүлэхтэй холбоотой саналыг зөвлөлд танилцуулна.

6.3. Ажлын хэсгийн ахлагч нь дараах үүрэгтэй:

6.3.1. Шалгалтын удирдамж, урьдчилан бэлтгэх баримт, материалын жагсаалтыг банкны гүйцэтгэх удирдлага, холбогдох нэгжийн удирдлагад танилцуулах;

6.3.2. Хянан шалгагч нарын ажил үүргийг хуваарилах, шалгалтын явцтай танилцах, заавар зөвлөгөө өгч, шалгалтыг үр дүнтэй, хугацаанд нь хийж дуусгах талаар санаачилгатай ажиллах;

6.3.3. Шалгалтын хугацаа сунгах бол энэ талаар удирдлагад хүсэлт гаргах;

6.3.4. Хяналт шалгалт дууссаны дараа удирдамжид заасан хугацаанд багтаан танилцуулга боловсруулах;

6.3.5. Шалгалтын акт материалыг Монголбанкны Банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт тавих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шалгалтын мөрөөр авах арга хэмжээний саналыг Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулан шийдвэр гаргуулах;

6.3.6. Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрийг банканд хүргүүлэх арга хэмжээг авч, шалгалтын танилцуулга, холбогдох баримт, материалыг банкны хувийн хэрэгт хадгалах.

6.4. Хяналт шалгалтын явцад шаардлагатай мэдээллийг цаасаар болон цахим сувгаар авч, холбогдох хууль, журамд заасны дагуу аюулгүй байдлыг хангаж ажиллана.

ДОЛОО. ХАРИУЦЛАГА

7.1. Энэхүү журмыг зөрчсөн бол холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

7.2. Илэрсэн зорчил, дутагдал эрүүгийн шинжтэй бол хянан шалгагч нь нэн даруй Банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт тавих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

—oOo—